

2026 он 8 сар 4 өдөр

№ 26/14

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах, бодлого батлах тухай*

Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.8, 76.1.18 дахь хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 7 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 6 сарын 26-ны өдрийн 26/12 дугаар тогтоолоор батлагдсан Захирлуудын зөвлөлийн бүрэлдэхүүнд дараах этгээдийг гишүүнээр **НЭМСҮГЭЙ**.
 - а. Б.Баттулга - Дижитал шилжилт хариуцсан захирал
2. Компанийн шинэчилсэн цалин урамшууллын бодлогыг нэгдүгээр хавсралтаар, Хөрөнгө оруулагчтай харилцах бодлогыг хоёрдугаар хавсралтаар тус тус **БАТАЛСУГАЙ**.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захирлуудын зөвлөлд **ДААЛГАСУГАЙ**.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2026 он 8 сар 4 өдөр

№ 26/13

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Данс нээх тухай

Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.18 дахь хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 7 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн үйл ажиллагаатай холбогдуулан Компанийн нэр дээр Blockchain.com платформд арилжаа болон кастоди (trading and custody) данс нээхийг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ**.
2. Дараах албан тушаалтнуудад дээрх данстай холбоотой бүх төрлийн үйл ажиллагааг Компанийн нэрийн өмнөөс хэрэгжүүлэх, шаардлагатай баримт бичигт гарын үсэг зурах, хүсэлт гаргах, баталгаажуулах болон холбогдох бусад бүх арга хэмжээг авах эрхийг **ОЛГОСУГАЙ**:
 - Г.Уянга, Ерөнхий захирал
 - А.Азбаяр, Компанийн нарийн бичгийн дарга
3. Дээр дурдсан эрх бүхий этгээдүүд нь Blockchain.com-д данс нээх, ажиллуулах, хадгалахтай холбоотой бүх баримт бичигт гарын үсэг зурах, шаардлагатай бүх мэдээллийг гаргаж өгөх, мөн дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааг компанийн нэрийн өмнөөс хийх эрхийг **ОЛГОСУГАЙ**.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ